



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/70

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдах
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрх сунгах,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй ОИГ, Жонийн булаг, Жинд болор, Ирмүүн түшиг, Чандмань норовлингаа ХХК-ны хүнсний дэлгүүрүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, Сайн мандал, Баянцахилдаг, Ээлт бор хайрхан ХХК-ны зоогийн газрын архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус сунгасугай.

Хоёр. Адаацаг сумын Санжаасүрэн ХХК-ны архи согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс хүчингүй болгосугай.

Гурав. ОИГ, Жонийн булаг, Жинд болор, Ирмүүн түшиг, Сайн мандал, Баянцахилдаг, Ээлт бор хайрхан ХХК-ниудын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08.00-24.00, Чандмань норовлингаа ХХК-ны ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08.00-21.00 цаг хүртэл хугацаагаар баталсугай.

Дөрөв. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (О.Амарсанаа), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Адаацаг, Сайнцагаан, Дэрэн сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010187